

“ХӨВСГӨЛ ХК”-ийн №23/01 тоот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХӨВСГӨЛ ХК-н хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 12 цагаас Ард Апп, зүүм апп ашиглан цахим хэлбэрээр амжилттай эхлэв.

Хуралд оролцогчид:

- ТУЗ-н дарга Г.Уянга,
- ТУЗ-н гишүүн Ц.Тайшир,
- Хувьцаа эзэмшигч Ц. Батбаяр,
- Хувьцаа эзэмшигч Э.Номинчимэг,
- Хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирал Г.Сэлэнгэ,
- Тооллогын комисс дарга Д.Энхбилэг,
- Тооллогын комисс гишүүн И.Дөлгөөн,
- Тооллогын комисс гишүүн Г.Урангоо,
- Хөндлөнгийн ажиглагч Ард Секюритиз ҮЦК дэд захирал Г.Долгорсүрэн нар оролцов.

Хурлыг нээж Хурлын дарга Г.Уянга хувьцаа эзэмшигчдэд хандан хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Тооллогын комиссын даргыг хурлын ирцийг танилцуулахыг хүсэв.

Тооллогын комиссын дарга Д.Энхбилэг дараах байдлаар танилцуулав.

Хөвсгөл ХК-ийн 2023 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулагдаж байна. Компанийн гаргасан нийт **51,956** ширхэг энгийн хувьцааны **48,690** ширхэг буюу **93.71** хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасныг үндэслэн нийт саналын эрхтэй **93.71** хувийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байх тул Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсон тухай хурлын дарга Г.Уянга мэдэгдэж, хурлыг нээв.

Гүйцэтгэх захирал Г.Сэлэнгэ дараах байдлаар 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангаа танилцуулав.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1

Хөвсгөл ХК нь Монголын Хөрөнгийн Бирж ХК-д бүртгэлтэй нээлттэй Хувьцаат компани юм. Сүүлийн жилүүдэд үндсэн үйл ажиллагаа явуулаагүй. Нийт хөрөнгө, эздийн өмч болон өр төлбөр байхгүй болно. Хаяг нь Хөвсгөл аймагт бүртгэлтэй.

2022 оны жилийн эцсийн байдлаар Хөвсгөл ХК-н нийт хувьцааг 36 хувь хүн, хуулийн этгээд эзэмшиж байна. 3 хувьцаа эзэмшигч нийт хувьцааны 93.71 хувийг буюу 48,690 ш, бусад хувьцаа эзэмшигч нь 6.2 хувь буюу 3,266 ш хувьцааг тус тус эзэмшиж байна.

Ногдол ашгийн хувьд мөн адил үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотойгоор хувиарлаагүй болно.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2

2021 онд Грант Торнтон аудитын зөвлөмжийн дагуу аудитлагдсан тайлангаар Хөвсгөл ХК-ийн санхүүгийн тайланд өөрчлөлт оруулсан. 2022 онд үйл ажиллагаа явуулаагүй тул санхүүгийн тайланд өөрчлөлт ороогүй.

Хурлын дарга Г.Уянга: Хэлэлцэх асуудлуудаа танилцуулж дууслаа. Дээрх хэлэлцэх асуудлууд дээр нэмж саналаа хэлэх хувьцаа эзэмшигч болон ТУЗ-н гишүүн байвал саналаа хэлнэ үү.

Батбаяр: санал байхгүй

Номинчимэг: санал байхгүй

САНАЛ ХУРААЛТ

Тооллогын комиссын дарга Д.Энхбилэг: Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсэгт заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэсний үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай санал хураалтын дүн:
 - 1.1. **Зөвшөөрсөн: 48,690** ширхэг буюу **100 хувь**
 - 1.2. **Татгалзсан:** байхгүй
 - 1.3. **Түдгэлзсэн:** байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай санал хураалтын дүн:
 - 2.1. **Зөвшөөрсөн: 48,690** ширхэг буюу **100 хувь**
 - 2.2. **Татгалзсан:** байхгүй
 - 2.3. **Түдгэлзсэн:** байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.
 - 2.4. 7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.
3. Хүчингүй болсон саналын хуудасны тоо: байхгүй
4. **Санал өгөөгүй хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоо:**
 - 4.1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн тоо 0 ширхэг буюу 0%-ийн санал;

4.2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн тоо 0 ширхэг буюу 0%-ийн санал;

ХУРЛЫН ХААЛТ

Хурлын дарга Г.Уянга, гүйцэтгэх захирал Г.Сэлэнгэ, тооллогын комисс зүгээс хөрөнгө оруулагч, гүйцэтгэх албаны хамт олонд талархал илэрхийлэн хурлыг хаав.


Хурал 12:20-д дуусав.

Хянасан,

Хурлын дарга

Гүйцэтгэх захирал

Тэмдэглэл хөтөлсөн



Г.Уянга

Г.Сэлэнгэ

Д.Энхбилэг